



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/94

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Виртуал орчин, Дижитал музей бий болгох /Орон Нутгийг Судлах Музей/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202312017 дугаартай тендерийн Багц-2 Дижитал музей бий болгоход зориулалтай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг 21,765,580 (Хорин нэгэн сая долоон зуун жаран таван мянга таван зуун наян) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Би Си Ти” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Виртуал орчин, Дижитал музей бий болгох /Орон Нутгийг Судлах Музей/ гүйцэтгэгч сонгох тендерийн Багц-2 Дижитал музей бий болгоход зориулалтай тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавих, гэрээ дүгнэх, боловсруулсан техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Х.Рагчаа (Аймгийн Орон нутгийн судлах музейн захирал)

Ө.Батмягмар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэлийн ажилтан)

Х.Батмөнх (“Би Си Ти” ХХК-ний гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга М.Одмаа (Аймгийн Орон нутгийн судлах музейн эрдэм шинжилгээний ажилтан)

3. Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах, гэрээг дүгнэх, Виртуал орчин, Дижитал музей бий болгох /Орон Нутгийг Судлах Музей/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202312017 дугаартай тендерийн Багц-2 Дижитал музей бий болгоход зориулалтай тоног төхөөрөмж хүлээн авах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д, ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажлын удирдамжийг батлуулж, гэрээ байгуулах, гэрээ дүгнэж, бараа, ажил үйлчилгээ хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, ажлын хэсгийн үйл ажиллагааны тайлан, бусад баримт бичгийг хүлээн авч, архивын нэгж үүсгэн тайлагнахыг Орон нутгийн өмчийн

d/zahiramj

6711010436

газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ш. ИДЭРБАЯСГАЛАН